

ХҮНСНИЙ БУУДАЙН НЭГЖИЙН ӨРТӨГ ТООЦОХ СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС

Abstract

The study was aimed to determine the value of the wheat which was planted and produced in the Mongolian main agricultural area, to analysis the effecting factors to the wheat valuation, to increase competency by value thus, to give recommendation on making policy making.

The research team have done the research study with internationally recognized methodology for agriculture specially for wheat valuation and also, used the methodology of the domestic researches for this study. We paralled the study methodology both domestic researcher's approach and internationally recognized approaches. Thus, we used the calculation method for unit wheat value as at first, calculated total cost for the 1 hectar, then compared it to the wheat harvest amount. In the result of it, we determined the cost of the unit wheat.

The data was collected from 150 entities and individuals who planted over 50 thousand hectars in four different agricultural areas. We divided all data into 9 different groups then analysed it.

The hectar's total cost and the product's unit value were calculated by each agricultural area then we used sampling. Accoring to average of the study sampling, the total cost of the 1 hectar has been increasing by 40'000 MNT to 43'000 MNT each year but unit wheat value increased at 354'100 MNT in 2013 from previuos year as 292'200 MNT in 2012 then it decreased at 298'200 MNT in 2014.

There are 30 different types of cost used for the calculating the 1 hectar's total cost. The biggest percent located cost are also analysed by agricultural area and planted square meter. Finally, we gave some conclusion and recommendation for wheat unit valuation.

Түлхүүр үг: *Үндсэн бүтээгдэхүүн ногдох зардлаар тооцсон өртөг, Нийт зардлаар тооцсон өртөг,*

Удиртгал

Монгол төгрөгийн гадаад валюттай харьцах ханш жил ирэх тусам тогтмол буурч байна. Газар тариалангийн үйлдвэрлэлд бид ажиллах хүчнээс бусдыг бараг бүгдийг нь импортоор авдаг. Мөн манай орны хөрсны үржил шим муугаас энэ салбарын бүтээгдэхүүний өртөг жил ирэх тусам олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвараа алдаж байна. Үүний үр нөлөөгөөр дотоодын тариаланчид өөрийн эрхгүй импортын үр тариа, хүнсний ногооноос өндөр өртөгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсон.

Сүүлийн жилүүдэд засгийн газраас судалгаа хийж бүтээгдэхүүний өртгийг бууруулах арга хэмжээг авч эхлэж байгаа бөгөөд энэхүү судалгааны ажил нь уг ажлын нэг хэсэг болсон юм. Монгол улсад дотооддоо үйлдвэрлэж байгаа гурилын үнэ гадаадаас оруулсан импортын гурилын үнээс хямд байж чадахгүй байгаа нь буудай үйлдвэрлэгчдэд хүндрэл учруулж байна. Буудайн үнэ өссөнөөс малын тэжээлийн үнэ сүүлийн жилүүдэд өндөр үнэтэй байгаа нь өвөл хүндхэн тохиолдох үед малчдад маш их үнийн дарамт үүсгэдэг.

Түүнчлэн үрийн буудайн үнэ импортын үрийн буудайн үнээс хэд дахин өндөр байгаа зэрэг шалтгаан гурилын гол түүхий эд болох улаанбуудайн өртгийг бууруулахын тулд түүний өртгийг шинжилж өртөгт голлон нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлж, бодлогын шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгчдэд судлаачдын зүгээс үндэслэлтэй тооцоо, мэдээллээр хангах нь тулгамдсан асуудал болоод байна.

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь Монгол улсад газар тариалангийн үйлдвэрлэлийн голлох бүсүүдэд үйлдвэрлэгдэж буй улаанбуудайн өртгийг тодорхойлох, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг судлан өртөгийн хувьд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, улмаар цаашид баримтлах бодлогын шийдвэр гаргахад зөвлөмж гаргахад оршино.

Зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж хэрэгжүүлсэн. Үүнд:

• Тариалан эрхлэгчдээс улаанбуудайн өртгийн судалгаа авах аргачлал, асуулгын маягт боловсруулах

- Судалгааны ажлын хамрах хүрээг тодорхойлох
- Улаанбуудайн өртгийн судалгааны ажлын тоо мэдээллийг цуглуулах
- Улаанбуудайн өртөгт нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээ хийх
- Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах

Тус судалгааны багаас олон улсын болон дотоодын нэр бүхий судлаачдын ХАА-н тэр дундаа буудайн өртөг тооцоход ашиглаж ирсэн тодорхой арга зүй, хувилбаруудыг зэрэгцүүлэн судалсны үндсэн дээр манай орны газар тариалангийн үйлдвэрлэлийн онцлогт нийцэхүйц судалгааны арга зүйг сонгосон болно. Ингэхдээ га-гийн зардалыг тодорхойлсны эцэст ургацад харьцуулах замаар нэгжийн өртөгийг тооцох аргыг ашиглав.

Судалгааны ажилд шаардлагатай мэдээллийг цуглуулахдаа түүвэр судалгааны аргаар сонгогдсон иргэн, аж ахуйн нэгжүүдээс:

- Асуулгын хуудас,
- Ганцаарчилсан болон нийтийн ярилцлага,
- Ажиглалтын болон ажлын Дүрслэл авалт хийх аргуудыг ашигласан.

Мөн Тариалангийн хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн актууд, ТЭДС-гаас гаргасан холбогдох суурь мэдээллүүдийг ашиглах замаар мэдээллийн баазыг байгуулсан.

Дээрх аргуудаас үндсэн мэдээллийн баазыг байгуулахдаа асуулгын хуудас бөглүүлэх замаар голлох мэдээллийг бүрдүүлсэн.

Энэхүү судалгааны ажилд буудайн өртөгийг тодорхойлохдоо газар тариалангийн бүтээгдэхүүний өртгийн тооцооны аргуудаас “Үндсэн бүтээгдэхүүнд ногдох зардлын арга”-ыг хамгийн зохистой гэж дүгнэн сонгон авч ашигласан.

Буудай тариалагч иргэн, аж ахуйн нэгжийн зардлыг ангилахдаа зардлын үндсэн ангиллаар (Хөдөлмөрийн зардал, Материалын зардал, Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал гэх) 3 үндсэн бүлэгт хуваан тодорхойлсон бөгөөд тухайн салбарын онцлогоос хамаарч зарим удирдлагын зардалуудыг, тухайлбал удирдлагын шатахуун, бичиг хэрэг, зээлийн хүү гэх мэтийг бүтээгдэхүүний өртөгт шингээн оруулсан болно. Үйлдвэрлэлийн нийт зардлыг 33 нэр төрлөөр судлав.

Судалгааны цар хүрээ: Судалгаанд хамруулах иргэн, ААН (Аж ахуйн нэгж)-ийг сонгохын тулд цаг хугацаа болон зардлын хүчин зүйлсийг үндэслэн газар зүйн байршлын хувьд алслагдмал аймаг, сумдыг хасаж газар тариалангийн голлох бүс нутгуудад судалгаа хийхээр төлөвлөсөн. Сонгогдсон бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 596 иргэн, аж ахуйн нэгж байгаагаас 10 аймгийн 37 сумын 150 иргэн, аж ахуй судалгаанд оролцсон нь төлөөлөх чадвар 25.2% байна.

Судалгаанд хамрагдсан иргэн, ААН-ийг газар тариалангийн үндсэн 4 бүсэд хуваан судалсан бөгөөд нийт хамруулахаар төлөвлөсөн 596 иргэн, ААН-ээс Зүүн бүсийн 43%, Өндөрлөг бүсийн 43%, Завсрын бүсийн 33%, Төвийн бүсийн 20%-ийг хамруулж чадсан.

Иргэн, аж ахуйн нэгжүүдийн хүчин чадал өөр өөр байгаа учир аж ахуйн нэгжүүдийг тариалсан талбайнаас нь хамааруулж 9 бүлэг болгон бүлэглэв.

Судалгааны хэсэг: Буудайн өртөг тооцсон судалгаа

Буудайн үйлдвэрлэл өндөр хөгжсөн орнуудад судлаачдын тодорхойлсноор буудайн өртөгт нөлөөлж буй үндсэн гол хүчин зүйл нь тариалж буй талбайн хэмжээ тул бид буудайн үйлдвэрлэлийн талбайн хэмжээг 9-н бүлгээр судалгааг боловсрууллаа.


Газар тариалангийн бүтээгдэхүүний өртөгт голлох нөлөө үзүүлэх хүчин зүйл нь нэгж талбайн ургацын хэмжээ байдаг. Судалгаанд хамрагсдын га-гийн ургацыг авч үзэхэд голлох бүс болон Төвийн бүс, мөн Завсрын бүсэд 2013 онд га-гийн ургац маш бага гарсан нь нийт түүврийн дундаж га-гийн ургац тус онд бага гарах шалтгаан болсон. Харин 2014 онд улсын хэмжээнд га-гийн ургац маш өндөр байсан. Цаашид судалгааны үр дүн болох буудайн өртөг га-гийн ургацаас шалтгаалан 2013 онд өндөр, 2014 онд эрс бага гарах магадлалтай.

Нийт 50 мянган га орчим талбайтай 150 аж ахуйн 85 мянга гаруй тонн ургац үүний 74 мянган тонн буудайн өртгийн тооцоонд үндэслэсэн учир судалгаа нь цар хүрээний хувьд өндөр болно. Га-гийн зардал, бүтээгдэхүүний нэгжийн өртгийг газар тариалангийн 4 бүс тус бүрээр нь тооцож гаргасан.

Түүвэр судалгааны үр дүн

Нийт түүврийн дунджаар га-гийн зардал жил бүр 40-43 мянган төгрөгөөр өсч байгаа бол буудайн нэгжийн өртөг 2012 онд 292.2 мянган төгрөг, 2013 онд 354.1 мянган төгрөг, 2014 онд 298.2 мянган төгрөг гарсан байна. 2014 онд буудайн нэгжийн өртөг бага гарсан нь тухайн жилд га-гийн ургац өндөр байсантай холбоотой.

Дүрслэл 1. Нийт түүврийн дундаж 1 га-гийн зардал ба өртөг, мян.төг



Нийт түүврийн дунжаар үйлдвэрлэлийн зардал болон ургацыг талбайн хэмжээгээр харахад га-гийн ургац дунд хэмжээний талбайтай аж ахуйд өндөр байна. Мөн томоохон хэмжээний аж ахуйд га-гийн ургац өндөр байна. Га-гийн зардал талбайн хэмжээнээс хамаараад буурч байгаад томоохон аж ахуйн нэгжид өндөр юм. Үүнээс улбаалаад Үндсэн бүтээгдэхүүнд ногдох зардлаар тооцсон өртөг жижиг аж ахуйд өндөр байгаад дунд хэмжээний талбайтай аж ахуйд багасаар том аж ахуйнуудад өндөр гарсан байна. Дайвар бүтээгдэхүүний борлуулалтын хувьд талбайн хэмжээнээс хамаараад нэмэгдэх хандлагатай байна.

Эх сурвалж: Судлаачдын судалгааны үр дүн

Түүврийн дундаж өртгийн бүтцийг зардлын ерөнхий ангиллаар авч үзэхэд 2014 онд хүнсний буудайн нэгжийн өртөгт ШХЗ 39.6 мянган төгрөг, ШМЗ 153.4 мянган төгрөг, ҮНЗ 105.1 мянган төгрөгийг эзлэж байна. Өөрөөр хэлбэл буудайн өртөгт хамгийн их хэмжээ эзэлдэг зардал нь шууд материалын зардал (үр, шатахуун гэх мэт) байна. Өртгийн бүтцэд эзлэж буй гол зардлуудын хувийн жинг талбайн хэмжээнээс хамааруулан авч үзэхэд үрийн буудайн зардал хамгийн өндөр хувийг эзлэж байгаа ба энэ нь талбайн ангилал тус бүрт харилцан адилгүй, ерөнхийдөө хандлага нь талбайн хэмжээ томрох тусам буурч байна. Шатахууны зардал талбайн ангилал тус бүрт мөн харилцан адилгүй ерөнхийдөө жигд хандлагатай байна. Харин үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал талбайн хэмжээ томрох тусам өсөх хандлагатай байна. Энэ нь аж ахуйн хэмжээ томрох тусам тариалангийн техник тоног төхөөрөмжийн хүчин чадал, үнэ нэмэгдэж илүү шинэ үнэтэй техник хэрэглэх болсоныг харуулна. Мөн сэлбэг хэрэгсэл болон урсгал засварын зардал талбайн хэмжээ томрох тусам буурч байгаа нь үүнтэй холбоотой.

Газар тариалангийн бүтээгдэхүүний өртөг судлаж байгаа бол бид зайлшгүй түүнд нөлөөлөх гол хүчин зүйл болох га-гийн зардал болон ургацыг авч үзэх шаардлагатай болно. Га-гийн зардлын бүтцийг шинжилж байж бид өртгийг бууруулах боломжтой юм. Тиймээс бид энэ дэд бүлэгт га-гийн зардлыг бүс болон талбайн ангилалын хувьд судалсан.

Мөн буудайн өртгийн бүтцийг талбайн хэмжээгээр ангилан харахад харилцан адилгүй байгаа нь үүнд газар тариалангийн техникийн насжилт нөлөөлж байх магадлалтай гэж үзээд бид судалгаандаа техникийн насжилтыг тооцож энэ нь зардалд хэрхэн нөлөөлж байгааг харуулахыг оролдсон.

Буудайн өртөгт нөлөөлөгч хүчин зүйлс

Га-гийн зардлыг зардлын ерөнхий ангиллаар нь хуваахад ШХЗ 2013 онд өссөн боловч 2014 онд буурсан байна. ШМЗ энэ онуудад 8-9.7% өсчээ. Харин ҮНЗ 2013 онд 17.6%, 2014 онд 11.6 хувь өссөн нь га-гийн зардал өсөхөд голло нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт №1. Судалгаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн га-гийн зардал, ерөнхий ангиллаар

дд	Зардлын бүлэг	2012	2013		2014	
			Дүн, ₮	Өөрчлөлт	Дүн, ₮	Өөрчлөлт
1	Шууд хөдөлмөр	61,595	66,460	7.9%	64,605	-2.8%
2	Шууд материал	211,145	228,093	8.0%	250,115	9.7%
3	Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал	130,580	153,562	17.6%	171,340	11.6%
	Нийт	403,320	448,114	11.1%	486,060	8.5%

Эх сурвалж: Судлаачдын судалгааны үр дүн

Га-гийн зардлыг дэлгэрэнгүй задалж үзэхэд ШМЗ-аас үрийн буудайн зардал хамгийн их хэмжээтэй болон өндөр өсөлттэй байна. Энэ нь үрийн буудайн үнэ жил бүр нэмэгдэж байгаатай холбоотой. Мөн ургамал хамгааллын бодис, бордооны зардал өндөр өсөлттэй байна. 2014 онд мөн тариалантын шатахууны зардал өндөр өсөлттэй гарчээ.

ҮНЗ-аас Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, Хангамжийн материалын зардал, Түрээсийн зардал хамгийн их хэмжээтэй болон өндөр өсөлттэй байна. 2014 онд урамшууллын цалингийн зардал

хамгийн өндөр өсөлттэй байгаа нь тус онд өндөр ургац авснаар аж ахуйн нэгжүүд ашигтай ажиллаж ажилчиддаа их хэмжээний урамшуулал олгож чадсаныг харуулна.

Га-гийн зардлыг бүх бүсээр түүврийн дундажтай харьцуулаханд Завсрын бүсэд ҮНЗ өндөр байна (Ачаа тээврийн түрээс, элэгдлийн зардал гэх мэт). Завсрын бүсэд Архангай аймгийн төвшрүүлэх, Өвөрхангай аймгийн Хархорин сумдын тариаланчид багтаж байгаа ба тэдгээрийн хувьд хамгийн ойр гурилын үйлдвэр нь Улаанбаатар хотод 370 орчим километр зайтай учир ачаа тээврийн түрээс хамгийн өндөр гарч дээрх зардал өсдөг.

Төвийн бүсэд ШМЗ, ШХЗ өндөр боловч ҮНЗ бага байна. Энэ нь төвийн бүсийн тариаланчид элеватор, гурилын үйлдвэртээ ойрхон учир ачаа тээврийн түрээсийн зардал бага гардагтай холбоотой.

Зүүн бүсэд ШХЗ, ШМЗ бага байна (Цалингийн зардал, шатахууны зардал гэх мэт).

Өндөрлөг бүсийн га-гийн зардалын бүтэц нийт түүврийн дундажтай хамгийн ойролцоо гарсан байна.

Дүрслэл 2. Га-гийн зардал, зардлын үндсэн ангилалаар, бүсээр, 2014




Эх сурвалж: Судлаачдын судалгааны үр дүн

Нийт га-гийн зардлыг бүсээр авч үзэхэд 2014 онд Зүүн бүсийн га-гийн зардал хамгийн бага байгаа бол Завсрын бүсийн га-гийн зардал хамгийн өндөр гарсан.

Нийт түүврийн дундаж га-гийн зардлыг талбайн ангилалаар авч үзэхэд ерөнхийдөө талбайн хэмжээнээс хамаараад буурах хандлагатай боловч томоохон аж ахуйн нэгжид өсч байна.


Дүрслэл 3. Нийт түүврийн дундаж га-гийн зардал, 2014



Эх сурвалж: Судлаачдын судалгааны үр дүн

Үүнийг задлан зардлын ерөнхий ангиллаар нь харуулахад ШХЗ (цалин, НДШ гэх мэт) талбайн хэмжээнээс хамаарч буурах хандлагатай байна. ШМЗ (шатахуун, үр гэх мэт) мөн талбайн хэмжээнээс хамаарч буурах хандлагатай. ҮНЗ (элэгдэл, зээлийн хүү, түрээс гэх мэт) талбайн хэмжээнээс хамаарч өсөх хандлагатай байна. ҮНЗ-д ШБХЗ (урамшуулал) болон ШБМЗ (хангамжийн зүйл, урсгал засвар) талбайн хэмжээ нэмэгдэхэд буурах хандлагатай. Харин бусад шууд бус зардал (Түрээс, Зээлийн хүү, Элэгдлийн зардал) нь ҮНЗ-ийн дийлэнхийг эзлэж байна. ҮНЗ талбайн хэмжээнээс хамааран өсөхөд элэгдлийн зардал хамгийн өндөр нөлөөтэй нь судалгаанаас харагдаж байна.

Дүрслэл 4. Га-гийн зардал, зардлын үндсэн ангилалаар, талбайн хэмжээгээр, 2014



Эх сурвалж: Судлаачдын судалгааны үр дүн

Нийт 30 нэр төрлийн зардлын үзүүлэлтээс га-гийн зардалд хамгийн өндөр хэмжээ эзлэж буй 8 зардлыг бид доор ялган харуулав.

Га-гийн зардалд хамгийн өндөр хувь эзлэж байгаа нь үрийн буудайн зардал (19.7-22.2%), шатахууны зардал (тариалалт, уринш, ургамал хамгааллын бодис бордоо цацах, хураах) (17.1-20.9%), үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал (14.9-16.2%), нийт цалингийн зардал/ үндсэн ажилчид, хийснээр цалин, гэрээт ажилчидын цалин/ (12-13.8%)-ууд байна.

Дараагийн томоохон зардлууд нь сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардал, түрээсийн зардал, ургамал хамгааллын бодисын зардал, зээлийн хүүгийн зардлууд байна.


Голлох 8 зардлыг бүсээр ангилбал 2014 онд үрийн буудайн га-гийн зардал Төвийн бүс болон Завсрын бүсэд хамгийн өндөр, шатахууны зардал, цалингийн зардал, зээлийн хүүгийн зардал болон түрээсийн зардал Завсрын бүсэд, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал Зүүн бүсэд хамгийн өндөр, ургамал хамгааллын бодисын зардал Өндөрлөг бүсэд хамгийн өндөр байна.

Га-гийн зардал хамгийн өндөр хувьтай эхний 4 гол зардлыг талбайн ангилалаар авч үзвэл үрийн буудайн зардал талбайн хэмжээнээс хамаарч буурах хандлагатай байна. Энэ нь том аж ахуйнууд өөрсдийн гэсэн үр нөөцлөх агуулахтай учир үрээ нөөцлөж хямд үрээс өөрсдийгөө хангаж чадаж байгааг илтгэнэ.

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал талбайн хэмжээнээс хамаарч өсөх хандлагатай байгаа нь томоохон аж ахуйнууд шинэ, өндөр үнэтэй техник ашиглаж байгаатай холбоотой бөгөөд үүнийг дагаад ажлын бүтээмж нэмэгдэж хүний оролцоо багассанаар цалингийн зардал талбайн хэмжээнээс хамаарч буурч байна.

Шатахууны зардал ерөнхийдөө талбайн хэмжээ тус бүрт жигд хандлагатай харагдаж байгаа учир уг зардлыг технологийн ажилбар тус бүрээр харуулна.

Дүрслэл 5. Га-гийн зардалд эзлэх голлох зардлуудын хэмжээ, талбайн хэмжээгээр, 2014 онд




Эх сурвалж: Судлаачдын судалгааны үр дүн

Га-гийн зардал хамгийн өндөр хувь эзлэж буй дараагийн голлох 4 зардлаас сэлбэг хэрэгсэл ба урсгал засварын зардал талбайн хэмжээ томрох тусам буурч байгаа нь техникийн шинэчлэлтэй холбоотой. Томоохон аж ахуйнууд сүүлийн үеийн шинэ техник ашиглаж байгаа тул энэ төрлийн зардал бага гарч байна. Түрээсийн зардал талбайн хэмжээ тус бүрт харилцан адилгүй байна. Гол

онцлог нь жижиг аж ахуйд техникийн түрээсийн зардал өндөр бол дунд аж ахуйд талбайн түрээс, том аж ахуйд ачаа тээврийн түрээсийн зардал өндөр гардаг байна. Мөн ургамал хамгааллын бодисын зардал талбайн хэмжээнээс хамаарч өсч байгаа бол зээлийн хүүгийн зардал жигд байна.

Дүрслэл 6. Га-гийн зардалд эзлэх голлох зардлуудын хэмжээ, талбайн хэмжээгээр, 2014 онд



Эх сурвалж: Судлаачдын судалгааны үр дүн

Судалгааны дүгнэлт

Газар тариалангийн дөрвөн бүс нутагт 50 гаруй мянган га талбайд тариалалт хийсэн 150 иргэн, аж ахуйн нэгжийг сонгож тариалсан талбай, газар зүйн байршлын хувьд ангилан үндсэн 9 бүлгээр судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

- Га-гийн ургац бүтээгдэхүүний нэгжийн өртөгт голлох нөлөө үзүүлж байна. Га-гийн зардал тогтмол үед Га-гийн ургац 1 цн-р нэмэгдэхэд өртөг 15122 төгрөгөөр буурч байна

- Га-гийн зардал өсөн нэмэгдэх нь бүтээгдэхүүний өртгийг нэмэгдэх үндсэн шалтгаан болж байна. Га-гийн ургац тогтмол үед га-гийн зардал 1000 төгрөгөөр нэмэгдэхэд өртөг 123 төгрөгөөр өсч байна.

- Цаашид бүтээмж өндөртэй, чанарын шаардлага хангасан үйлдвэрлэл явуулах нь чухал гэдгийг харуулж байна.

- Нийт түүврийн дунджаар Га-гийн зардал талбайн хэмжээ томрох тусам буурах хандлагатай байна.

- Талбайн хэмжээнээс хамааралтай зардлын бүтцийг судлахад хөдөлмөрийн болон материалын зардал буурч, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал өсөх хандлагатай байна. Энэ нь аж ахуйн нэгжийн хэмжээ томрох тусам техникийн хүчин чадал нэмэгдсэнтэй холбоотой.

- Мөн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг дэлгэрэнгүй ангиллаар судлахад бага талбай бүхий аж ахуйн нэгжид техникийн түрээсийн зардал, дунд аж ахуйн нэгжид зээлийн хүүгийн зардал, томоохон аж ахуйн нэгжид үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал өндөр байна.

- Га-гийн зардалд нийт 33 төрлийн зардлын үзүүлэлтээс 8 төрлийн зардал зонхилох 84-86%-ийг эзэлдэг байна. Үүнд:

- Үрийн, шатахууны, үндсэн хөрөнгийн элэгдлийн, цалингийн зардлууд (12-22%) өндөр хувьтай бөгөөд элэгдлийн зардал талбайн хэмжээнээс хамаарч өсч байхад бусад зардлууд буурсан байна.

- Техникийн насжилт нь жижиг болон дунд талбай бүхий аж ахуйн нэгжид өндөр буюу хуучирсан, дундаас дээш, томоохон аж ахуйн нэгжид харьцангуй шинэ байна.

- Нийт түүврийн дунджаар ХАА-н техникийн 60% нь 15-аас дээш жил үйлдвэрлэлд ашигласан байгаа нь энэ салбарт агропаркийн шинэчлэлийн зөв, оновчтой бодлого чухал байгааг харуулж байна.

Зөвлөмж

- Таримал үр, сорт, үр үржүүлгийн аж ахуйг бүсчлэн байгуулах хөгжүүлэх, бодлогоор дэмжих, (байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон)

- Ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээг төлөвшүүлэх,

- Хатуу буудайн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх, (Цавуулагийг сайжруулах, худалдан авах үнэ, урамшууллыг ялгавартай тогтоох)

- Цаашид төсвийн хөрөнгөөр болон бодлогын түвшинд парк шинэчлэл хийсэн тохиолдолд тухайн техникийн хүчин чадалтай тэнцэхүйц эргэлтийн талбайтай байхыг шаардах нь бүтээгдэхүүний өртгийг бууруулахад чухал ач холбогдолтой.

- Хүнсний буудайн урамшууллыг буудайн чанар болон газар зүйн байршилтай уялдуулан ялгавартайгаар олгож буй байдлыг илүү төгөлдөржүүлэх,
- Эргүүлэн хагалах уламжлалт технологиос татгалзан цомхотгосон болон тэг элдэншүүлэлтийн технологийн хэрэглээг нэмэгдүүлэх, өргөжүүлэх талаар авч хэрэгжүүлж буй бодлогоо үргэлжүүлэх,
- Жижиг аж ахуйн нэгж, иргэдийг газраар хорших, хамтран ажиллах сонирхлыг бий болгох үндсэн дээр тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлэх, шинэ технологи эзэмших, аж ахуйг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэн хөтлөх аргад суралцах сургалтыг системтэйгээр явуулах
- Салбарын өмнө тулгарч байгаа зайлшгүй шийдвэрлэвэл зохих зарим асуудлыг салбарын эрдэмтдийн оролцоогоор шийдвэрлэх, хамтран ажиллах,
- Хүний нөөцийг хөгжүүлэх (механикжуулагчийг сургаж дадлагажуулах)

Ном зүй

1. Агваан.Н, (2006), Үйлдвэрийн газрын санхүүгийн бүртгэл, УБ
2. Асри Хаммер, (2000), Зардлын нягтлан бодох бүртгэл, УБ
3. Жааваа.Т, (2003), Удирдлагын нягтлан бодох бүртгэл, УБ
4. Жамъяансүрэн.Ж, (2003), Бизнесийн шинжилгээ ба үнэлгээ, УБ
5. Нансалмаа.Я, (2003), Зардлын нягтлан бодох бүртгэл, УБ
6. Өлзийбат.С, (2014), Зардал удирдлагын бүртгэл, УБ
7. Саранчимэг.А, (2003), Зардлын бүртгэл, УБ
8. Тунгалаг.Н, (2004), Зардлын удирдлагын бүртгэл, УБ
9. Чойжилсүрэн.О, Батжаргал.Р, Самданжамц.Н, (1990), “Хөдөө аж ахуйн нягтлан бодох бүртгэл”, УБ
10. Жамъянхорлоо.Г, Нямбат.Л, Үйлдвэрлэлийн үр ашигт нөлөөлсөн хүчин зүйлсийн шинжилгээний арга зүйн гол асуудал,
11. Монгол улсын засгийн газар, үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, (2011) “Тариалангийн төв бүсэд техникийн засварын дундын төв байгуулах” төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, УБ
12. Монгол улсын үндэсний статистикийн хороо, (2012), Хөдөө аж ахуйн салбар, 2012 онд
13. Нямдаваа.Б, Алтанцэцэг.С, Батхуяг.М, Баярхүү.С, (2015), Хөдөө аж ахуйн салбар дахь төсвийн хөрөнгө оруулалтын судалгаа, цаашид баримтлах чиглэл боловсруулах” судалгааны ажлын тайлан, ХААИС
14. Нямдаваа.Б, Кадырбек.Д, Меруерт.О, Энх-Амгалан.Г, (2014), “Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын хэрэглэгчийн үнэлгээ” судалгааны ажлын тайлан, ХААИС
15. Нямдаваа.Б, Мөнхбат.Ж, Алтанцэцэг.С, Баасансүх.Б, Пүрэв.Б, (2015), “Улаан буудайн өртөг, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгаа, цаашид хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох нь” судалгааны ажлын тайлан, ХААИС
16. Улсын Их Хурлын тогтоолын төсөл, (2012), Газар тариалангийн тогтвортой хөгжил хөтөлбөр, УБ
17. Эрхэмбаяр.Л, (2014), Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын ирээдүй, цаашдын чиг хандлага, УБ

Цахим мэдээллүүд

- **Error! Hyperlink reference not valid.** сан, www.eri.mn
- Мандах бүртгэл дээд сургууль, mandakhburtgel.edu.mn
- Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, www.namac.mn
- Нацагдорж.Д-ийн нэрэмжит Улаанбаатар хотын Нийтийн Төв Номын Сан, koha.pl.ub.gov.mn
- Сангийн яам, www.iltod.gov.mn
- Үндэсний статистикийн хороо, статистик мэдээлэл, 1212.mn
- Үндэсний статистикийн хороо, статистик мэдээлэл, www.nso.mn
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа мэдээллийн үндэсний төв, www.labornet.mn
- Хүнс, хөдөө аж ахуйн яам, www.mofa.gov.mn
- Шинжлэх ухаан технологийн сан, www.stf.mn